

**ҮНЭТ ЦААСНЫ
ТАНИЛЦУУЛГА**

Хүчтэй. Хамтдаа.

Хөрөнгө оруулагчдын анхааралд

Энэхүү Үнэт цаасны танилцуулга нь олон нийтэд мэдээлэл хүргэх зорилготой болно. Хөрөнгө оруулагч та Үнэт цаас гаргагч болоод түүний гаргаж буй үнэт цаас, холбогдох мэдээлэлд өөрийн хөндлөнгийн судалгаа шинжилгээг хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийхийг зөвлөхийн ялдамд мэргэжлийн санхүүгийн, хуулийн болон бусад холбогдох мэргэжилтнүүдтэй зөвлөлдөж, шийдвэрээ гаргахыг зөвлөж байна. Тус танилцуулгад багтсан тоон мэдээллүүд нь 2017 оны аудитлагдсан үзүүлэлт дээр үндэслэсэн бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж болон мэргэжлийн аудитын байгууллага нягтлан шалгаж, баталгаажуулсан болно.

“ҮНЭТ ЦААСЫГ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЭЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА”

Агуулга

7	Үнэт цаасны хураангуй танилцуулга
8	Товчилсон үгийн тайлбар
9	I. Үнэт цаас гаргагчийн танилцуулга
35	II. Үнэт цаасны танилцуулга

Үнэт цаас гаргахад хамтран ажилласан байгууллагууд

Хуулийн зөвлөх байгууллага

Нэр: Өмгөөллийн ИЭлСи ХХН
Хаяг: Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р Хороо,
Ардчиллын өргөө, 6 давхар
Утас: (976) 77118193
Вебсайт: www.elclawoffice.mn



Үнэлгээний байгууллага

Нэр: БДО Аудит ХХК
Хаяг: Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, ЮНЕСКО-гийн
гудамж, Нарны зам-62, Юнион Бюлдинг В-
блок, 15-р давхар, 1502 тоот
Утас: (976) 77404040, (976) 77404041
Вебсайт: www.bdo.mn



Аудитын байгууллага


Нэр: Далайван Аудит ХХК
Хаяг: Монгол Улс, Улаанбаатар-16066,
Амарсанаагийн гудамж-5, Далайван ХХК-ийн
байр
Утас: (976) 70005401
Вебсайт: www.dalaivanaudit.mn



Андеррайтер компани

Нэр: БиДиСЕК ҮЦК ХХК
Хаяг: БиДиСЕК ҮЦК ХК-ийн байр, Залуучуудын өргөн
чөлөө 27/1, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот,
Монгол улс
Утас: (976) 11 313108
Вебсайт: www.bdsec.mn





Үнэт цаасны хураангуй танилцуулга

Энэхүү үнэт цаасны танилцуулгыг Компанийн тухай хууль, Монголын Хөрөнгийн Биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”, Санхүүгийн Зохицуулах Хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам” болон Ард Даатгал ХХК-ийн 2018 оны 04 сарын 20-ны өдрийн Хувьцаа Эзэмшигчдийн хурлын 07/18 тоот тогтоолыг үндэслэн бэлтгэлээ.

Үнэт цаас гаргагч

Үнэт цаасны төрөл

Үнэт цаасны симбол

Бүртгүүлэх ангилал

Санал болгож буй хувьцааны нэгж үнэ

Санал болгож буй хувьцааны тоо ширхэг

Нийт татан төвлөрүүлэх дүн

Олон нийтэд санал болгож буй хувь

Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

Үнэт цаас арилжих арга

Ард Даатгал ХХК

Энгийн

MSE: AIC

МХБ-ийн Хувьцааны Бүртгэлийн I ангилал

700 төгрөг /долоон зуун төгрөг/

7,500,000 ширхэг энгийн хувьцаа

5,250,000,000 төгрөг /таван тэрбум хоёр зуун

тавин сая төгрөг/

30%

Дүрмийн сан болон өөрийн хөрөнгө

нэмэгдүүлэх

Тогтоосон үнийн арга

Товчилсон үгийн тайлбар

СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ҮЦЗЗ	Үнэт цаасны зах зээл
ҮЦЗЗТХ	Үнэт цаасны зах зээлийн тухай хууль
ЭСЯ	Элчин сайдын яам
КТХ	Компанийн тухай хууль
ХААДД	Хөдөө Аж Ахуйн Давхар Даатгал
МИД	Малын индексжүүлсэн даатгал
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХЗХ	Хадгаламж зээлийн хоршоо
ТББ	Төрийн бус байгууллага
ХНС	Хохирлын нөөц сан
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ҮЦК	Үнэт цаасны компани
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
МХБ	Монголын хөрөнгийн бирж
ДХО	Даатгалын хураамжийн орлого
НТ	Нөхөн төлбөр
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал



1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТАНИЛЦУУЛГА



Үнэт цаас гаргагчийн тухай

Компанийн нэр:

Үүсгэн байгуулагдсан он:

Үйл ажиллагаа:

Хувьцаа эзэмшигчдийн тоо:

Гаргасан хувьцааны тоо ширхэг:

Ард Даатгал ХХК /РД: 2062089/

1994 он

Гэнэтийн ослын, жуулчдын гэнэтийн осол, эрүүл мэнд, хөрөнгө, барилга угсралт, тээврийн хэрэгсэл, ачаа, зорчин явагч-тээвэрлэгчийн хариуцлага, зочид буудлын эзний хариуцлага, гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлага, давхар даатгалын үйлчилгээ (672000)

2 (2018.09.05-ны байдлаар)

17,500,000 ширхэг

Алсын хараа

Ард Даатгал компанийн хувьд даатгалын үйлчилгээ нь даатгуулагчдын эрэлт хэрэгцээ, шаардлагад бүрэн нийцсэн, тэдний амар тайван амьдралын баталгааг хангасан, нийгмийн хариуцлагыг дээдлэгч, ил тод нээлттэй, итгэл төрүүлсэн тэргүүлэгч даатгагч, даатгалын үйлчилгээг үзүүлэгч болох.

Эрхэм зорилго

Даатгуулагчийн хэрэгцээнд тохируулсан, ёс зүйг баримталсан, даатгалын шилдэг үйлчилгээг бид үзүүлнэ.



Компанийн танилцуулга

Ард Даатгал ХХК (цаашид “Үнэт цаас гаргагч” гэх) нь 1994 оны 3 сарын 14-ний өдөр Монголын **анхны хувийн даатгалын компани** болж байгуулагдсан бөгөөд 2004 онд хөрөнгө, санхүүгийн зах зээл дээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Их Британийн Виттингтон групп тус компанид хөрөнгө оруулалт хийж хувь нийлүүлэгч болсноор улсдаа гадаадын хөрөнгө оруулалттай **анхны даатгалын компани болж**, Европын даатгалын зах зээлийн шилдэг туршлага, олон улсын ноу хау-г Монгол улсын даатгалын зах зээлд авчирсан билээ.

2011 онд Ард Даатгал ХХК нь Гранд Даатгал ХХК-ийг өөртөө нэгтгэн үйл ажиллагааны цар хүрээгээ өргөжүүлж **даатгалын салбарт анхны нэгдлийг** амжилттай хэрэгжүүлсэн. 2015 оноос

Ард Санхүүгийн Нэгдэл хэмээх хүчирхэг санхүүгийн нэгдлийн бүрэлдэхүүнд нэгдэж бүтэц зохион байгуулалтын хувьд өөрчлөгдөн хэрэглэгч, харилцагчиддаа улам бүр ойртон ажиллаж байна. 2017 оны эцсээр 24 салбар, 238 төлөөлөгчөөр дамжуулан **63,633** харилцагчдад 50 гаруй бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэн хамтран ажиллаж байна.



Бүтэц, зохион байгуулалт



ТУЗ-ийн ГИШҮҮД

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийн эрх барих дээд байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) байна. ХК-ийн

дүрмийн төслийн 8.2-д зааснаар ТУЗ нь 9 (ес) гишүүнээс бүрдэх бөгөөд 1/3 нь хараат бус гишүүд байна.

ТУЗ-ийн гишүүдийн нэр	Албан тушаал	ТУЗ-ийн гишүүн	Компанийн засаглалын гэрчилгээний №
Ч.Ганхуяг	Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн гүйцэтгэх захирал	ТУЗ-ийн дарга	№0130277
Г.Цогбадрах	Ард Даатгал ХХК-ийн гүйцэтгэх захирал	Ердийн гишүүн	2012 оны 06 сарын 02-нд засаглалын гэрчилгээ авсан.
О.Одбаяр	Эрдэнэс Монгол ХХК-ийн дэд захирал	Хараат бус гишүүн	№0130273
Б.Гантулга	Сүү ХК-ийн гүйцэтгэх захирал	Хараат бус гишүүн	№0730472
А.Хоброу	НэксАссюр Групп болон Омни Бриджвэй Азиа компаниудын захирал	Ердийн гишүүн	№0130280
Б.Болорчимэг	MLC Training ХХК-д сургагч багшаар, NTV телевизд уран бүтээлийн газрын сэтгүүлч, хөтлөгч	Хараат бус гишүүн	Сургалтанд суухаар бүртгүүлсэн
Б.Золбоо	Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хөрөнгө оруулалт эрхэлсэн захирал	Ердийн гишүүн	№0130947
Ч.Ганзориг	Ард Кредит ББСБ ХХК-ийн гүйцэтгэх захирал, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн санхүү эрхэлсэн захирал	Ердийн гишүүн	№0430404
З.Ариун	Одод ХХК-д бизнес хариуцсан менежерээр, Insignia ХХК-ийн үүсгэн байгуулагч, захирал	Хараат бус гишүүн	№00064
Б.Ариунаа	Ард Даатгал ХХК-ийн хүний нөөцийн ахлах менежер	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	№0130821

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод

Нэр дэвшүүлэх, Засаглалын хороо



Ч.Ганжуяг
Хорооны дарга



Б.Болорчимэг



Энтони Хоброу



А.Батболд
Нарийн бичгийн
дарга

Эрсдэл, хөрөнгө оруулалтын хороо



Ч.Ганзориг
Хорооны дарга



Г.Цогбадрах



Б.Золбоо



Г.Баярбат
Нарийн бичгийн
дарга

Аудитын хороо



О.Одбаяр
Хорооны дарга



Б.Гантулга



З.Ариун



П.Бямбасүрэн
Нарийн бичгийн
дарга

Эрх бүхий албан тушаалтнууд

Үнэт цаас гаргагч нь **100 гаруй** ажиллагсадтайгаар даатгалын, эрсдэлийн удирдлагын, санхүү удирдлагын, үйл ажиллагааны газраар дамжуулан үйл ажиллагаа явуулдаг. Нийт ажиллагсадын 55 хувь нь хөдөө орон нутгийн 20 аймагт байрлах салбарт ажиллаж байна.

Эрх бүхий албан тушаалтнууд	Албан тушаал
Г.Цогбадрах	Гүйцэтгэх захирал
А.Батболд	Үйл ажиллагаа эрхэлсэн захирал
Н.Эрдэнэтулга	Даатгалын газрын захирал, дэд захирал
Т.Батцэнгэл	Санхүү удирдлагын газрын захирал
Ц.Тайшир	Эрсдэлийн удирдлагын газрын захирал
Д.Ангараг	Ерөнхий нягтлан бодогч

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

4.69%

Энержи Интернэйшнл Капитал ХХК /РД: 5790263/

Эзэмшлийн хувь: 820,750 ширхэг, 4.69%

Үйл ажиллагааны чиглэл: Бизнесийн зөвлөгөө

95.31%

Ард Санхүүгийн Нэгдэл ХК /РД: 5024145/

Эзэмшлийн хувь: 16,679,250 ширхэг буюу 95.31%

Үйл ажиллагааны чиглэл: Бизнесийн зөвлөгөө, хөрөнгө оруулалт

Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй манлай компаниудад хөрөнгө оруулалт хийж, зах зээл дэх байр суурь, өрсөлдөх чадвар болон үнэ цэнийг нь дээшлүүлэх замаар компанийн хувь нийлүүлэгчдийн өгөөжийг өсгөх зорилт тавин ажиллаж байгаа үндэсний санхүүгийн холдинг компани юм.




САНХҮҮГИЙН
НЭГДЭЛ

Ард Санхүүгийн Нэгдлийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид

Хувьцаа эзэмшигчийн нэр	Эзэмшиж буй хувьцааны тоо	Эзэмшиж буй хувь
Ард Секюритиз ҮЦК ХХК	3,286,567	19.11%
Х.Батхишиг	1,689,415	9.83%
Луна Энд Луна ХХК	1,333,154	7.75%
Бруно Рашле	1,317,337	7.66%
ВенчурсУан	1,316,103	7.65%
Ч.Ганхуяг	1,145,400	6.66%
Жинст Увс ХК	1,020,998	5.94%

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хөрөнгө оруулсан компаниуд



Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа

Даатгалын үйл ажиллагаа

Даатгалын үйл ажиллагаа нь гэрээний үндсэн дээр даатгуулагч зохих хураамж төлж өөрийн эд хөрөнгө, ашиг сонирхлоо болзошгүй эрсдэлээс учирч болох хохирлоо нөхөх баталгаатай эх үүсвэртэй байх болон даатгагч хураамж авсны үндсэн дээр даатгуулагчийн даатгуулсан зүйлд учирч болох хохирлыг бүрэн буюу хэсэгчлэн нөхөн төлөх үүрэг хүлээх, эрх эдлэх харилцаа юм.

Бидний үйлчилгээ

Үнэт цаас гаргагч нь ердийн даатгалын үйл ажиллагаа явуулдаг бөгөөд сайн дурын болон албан журмын төрөл бүхий Санхүүгийн Зохицуулах Хорооноос (СЗХ) тогтоосон сайн дурын даатгалын гэнэтийн осол, амь нас эрүүл мэнд, эд хөрөнгө, хариуцлага, санхүүгийн, газар тариалангийн, малын индексжүүлсэн даатгалын хэлбэрээр 50 гаруй даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлж байгаа төдийгүй “Жолоочийн даатгалын тухай” хуулийн дагуу жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хэрэгжүүлэгч даатгалын ууган компаниудын нэг юм.

Тус компани нь Монгол Улсын даатгалын салбарын тэргүүлэгч компани юм.

Хүний нөөц

Монгол Улсыг бүхэлд нь хамарсан сүлжээ бүхий 24 салбар нэгж, 238 гаруй төлөөлөгч, 100 гаруй үндсэн ажилтантайгаар даатгалын үйл ажиллагаагаа 24 дэх жилдээ амжилттай явуулж байна.

Ард Даатгал нь Монгол Улсын даатгалын зах зээлд 10-30 жил ажиллаж байгаа даатгалын чадварлаг боловсон хүчнийг бүрдүүлэн, олон жилийн турш эгнээндээ нэгтгэн ажилласны дүнд зах зээл дэх хамгийн туршлагатай ажилтнуудтай компани болсон байна.

Давхар даатгал

Үнэт цаас гаргагч нь давхар даатгуулахтай холбоотой үйл ажиллагааг Монгол улсын холбогдох хууль тогтоомж, СЗХ-ны дүрэм журамтай нийцүүлэн олон улсад мөрдөгддөг хэм хэмжээний дагуу явуулдаг ба энэ талаар олон жилийн ихээхэн туршлага хуримтлуулсан бөгөөд олон улсын давхар даатгалын зах зээлд нэр хүндтэй дотоодын даатгагч юм.



Ийм ч учраас дэлхийн томоохон давхар даагчийн нэг болох ХБНГУ-д төвтэй Европын Холбооны хамгийн том даатгалын групп Allianz нь Ард Даатгал компанийг Монгол дахь түншээр сонгож ажиллаж байгаа юм. Бид даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн хариуцлагаа бүтнээр болон хэсэгчлэн нэр хүнд бүхий давхар даатгалын брокеруудаар дамжуулан олон улсын даатгалын (ихэвчлэн Лондон, Ллойдсийн синдикатууд, ХБНГУ, Сингапур, Хонг Конг, ОХУ, Хятад) зах зээл дээр давхар даагч нарт даатгалын гэрээг баталгаатай, бодит үнээр, түргэн шуурхай борлуулан, хамгаалалт олж авдаг билээ. Мөн бид дэлхийн тэргүүлэх давхар даатгалын Hannover Re, Munich Re, Swiss Re зэрэг 20 гаруй компаниуд болон Монгол улсын давхар даатгагч Хөдөө аж ахуйн давхар даатгалын компанитай хамтран ажилладаг.

Давуу тал

2017 оны хувьд бид Hannover re, MSH International компаниудтай хамтран **Ard Medicare** олон улсын эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүнийг амжилттай нэвтрүүлсэн нь манай харилцагч, үйлчлүүлэгчдийн талархлыг хүлээсээр байна. Энэхүү бүтээгдэхүүн нь дэлхийн 200 орны 330,000 гаруй эмнэлгээр үйлчлүүлэх

боломжийг олгож байгаа бөгөөд өргөн хүрээ бүхий хамгаалалтыг харьцангуй хямд үнээр авах боломжийг харилцагчдад олгож буй бүтээгдэхүүн юм.

Мөн 2017 онд манай компани Хөдөө Аж Ахуйн Давхар Даатгал ХК-тай хамтран **газар тариалангийн даатгалыг** Монгол улсын даатгалын зах зээл дээр анх удаа хэрэгжүүлэх ажилд амжилттай оролцож дөрвөн аж ахуйн нэгжид 211 сая төгрөгийн нөхөн төлбөр олгожээ.

2016 оноос Малын индексжүүлсэн даатгалын борлуулалтанд оролцож эхэлсэн бөгөөд давхардсан тоогоор 889 малчин өрхийн 239 мянган толгой малыг даатгалд хамруулж, зуд болон байгалийн бусад төрлийн давагдашгүй хүчин зүйлээс хамгаалж ажиллаж байна.

Хураамжийн орлого

2017 оны жилийн эцсийн байдлаар үнэт цаас гаргагчийн нийт хураамжийн орлогын 41 хувийг хөрөнгийн даатгал, 17 хувийг жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, 13 хувийг авто тээврийн хэрэгслийн даатгал, 11 хувийг гэнэтийн осол, эмчилгээний даатгал эзэлж байна.

Хураамжийн орлогын бүтэц (сая төгрөгөөр)**Нөхөн төлбөр олголт (хувиар)**

Нөхөн төлбөр

Даатгалын салбарын хэмжээнд дундаж хохирол төлөлтийн харьцаа 31.4 хувь байсан бол Ард Даатгал компанийн хувьд нөхөн төлбөрийн цэвэр зардлын хувьд 24.5 хувь, нийт нөхөн төлбөртэй харьцуулахад 39.2 хувь байна. Энэхүү үзүүлэлт нь бид эрсдэлээ сайн тараан байршуулж, харилцагчиддаа давхар даатгалын нөхөн төлбөрийг амжилттай хүргэж, олон улсын стандартад нийцсэн үйлчилгээ үзүүлж буйг илтгэж байна.

Бид 2017 онд нийт 3,409 даатгуулагчдад 4.06 тэрбум төгрөгийн хохирлыг төлж барагдуулан, даатгалын гэрээний үүргээ нэр төртэйгээр биелүүллээ.

Нийт нөхөн төлбөрийн бүтцийн хувьд 2017 оны жилийн эцсийн байдлаар 32% хувийг барилга угсралтын даатгал, 19% хувийг жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, 16.5 хувийг авто тээрийн хэрэгслийн даатгал, 9.8% хувийг хөрөнгийн даатгал тус тус эзэлж байна.

Шуурхай алба

2015 оноос компани 24 цагийн үйл ажиллагаатай нөхөн төлбөрийн шуурхай

албыг байгуулан харилцагчдад түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх, даатгалын тохиолдлыг газар дээр нь баталгаажуулах, нөхөн төлбөрийн процессыг хяналттай түргэн шуурхай явуулах боломжийг бий болгосон билээ. Ажлын цагаар Улаанбаатар хотод Ард Даатгалын хоёр шуурхай алба зэрэг ажиллан, хотыг зүүн баруун бүсэд хуваан дуудлага хүлээн авч, түргэн шуурхай үйлчилж байна.

Ард Даатгалын шуурхай алба 7 хоног 24 цагийн турш 7720 0088 дугаараар дуудлага хүлээн авч түргэн шуурхай үйлчилгээ үзүүлж байна.

2017 онд шуурхай алба нийт 2,614 удаагийн дуудлага хүлээн авч, үүнээс 1,287 удаагийн тохиолдолд газар дээр нь шуурхай ажиллан, харилцагчдад зөвлөгөө мэдээлэл өгсөн байна. Улаанбаатар хотын замын ачаалал, хөдөлгөөний түгжрэл зэргээс шалтгаалан ослын газарт очих дундаж хугацаа 15-20 минут байгаа бөгөөд энэ хугацааг багасгах үүднээс шуурхай албыг нэмэлт хөдөлгөөнт хэрэгслээр хангах, скутэр мопед зэргийг ирэх жилээс шуурхай албандаа ашиглахаар төлөвлөж байна.


Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан

Сая төгрөгөөр	2015	2016	2017
ХӨРӨНГӨ			
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	2,405.74	405.15	793.31
Хөрөнгө оруулалт	2,669.58	4,395.17	5,783.66
Даатгалын авлага	1,418.84	1,367.47	885.06
Өмч, барилга, тоног, төхөөрөмж-цэвэр	1,551.72	278.29	2,032.56
НИЙТ ХӨРӨНГӨ	8,758.53	9,541.14	11,726.64
ӨР ТӨЛБӨР			
Даатгалын өр төлбөр	285.27	613.34	602,089.60
Орлогдод тооцоогүй хураамжийн нөөц	3,160.96	3,012.00	3,894,943.50
Нийт нөхөн төлбөрийн нөөц сан	1,370.66	1,343.18	1,664,648.60
НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,947.15	5,298.64	6,489.50
ЭЗНИЙ ӨМЧ			
Энгийн хувьцаа	3,500.00	3,500.00	3,500.00
Хуримтлагдсан ашиг	311.37	742.51	1,737.14
Эзний өмчийн дүн	3,811.37	4,242.51	5,237.14
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗНИЙ ӨМЧ	8,758.53	9,541.14	11,726.64

Үнэт цаас гаргагчийн орлогын тайлан

Сая төгрөгөөр	2015	2016	2017
Даатгалын үйл ажиллагаа			
Даатгалын хураамжийн орлого	9,159.63	7,172.29	10,355.13
Даатгалын хураамжийн буцаалт	(239.05)	(131.93)	(141.38)
Давхар даатгалын хураамжийн зардал	(1,841.98)	(1,346.38)	(3,301.85)
Даатгалын хураамжийн цэвэр орлого	7,078.60	5,693.98	6,911.89
Нөхөн төлбөрийн зардал	(3,828.56)	(2,595.76)	(4,063.12)
Давхар даатгагчийн төлсөн нөхөн төлбөр	-	-	1,529.57
Буруутай этгээд хариуцсан нөхөн төлбөр	-	32.48	22.68
Нөхөн төлбөрийн цэвэр зардал	(3,828.56)	(2,563.28)	(2,510.87)
Даатгалын гэрээний зардал	(1,390.19)	(994.55)	(916.66)
Давхар даатгалын шимтгэлийн орлого	88.39	45.64	128.25
Хөрөнгө оруулалтын орлого	580.46	801.37	1,400.03
Даатгалын үйл ажиллагааны ашиг/ алдагдал	3,550.68	4,154.14	4,745.64
Үйл ажиллагааны зардал	3,854.23	3,809.50	3,792.87
Татвар төлөхийн өмнөх ашиг/ алдагдал	(155.91)	489.62	1,260.03
Орлогын албан татварын зардал	(58.05)	(58.48)	(136.06)
Татварын дараах ашиг/ алдагдал	(213.96)	431.13	1,123.97


Хөрөнгө оруулалтын олз, гарз (сая төгрөг)




Санхүүгийн харьцаа үзүүлэлт


	2015	2016	2017
Цэвэр ашгийн маржин	-2.34%	6.01%	10.85%
Нийт хөрөнгийн эргэц	1.05	0.78	0.97
Санхүүгийн хөшүүрэг	2.17	2.27	2.24
Нийт эздийн өмчийн өгөөж (ROE)	-5.32%	10.71%	23.71%
Нийт хөрөнгийн өгөөж (ROA)	-2.45%	4.71%	10.57%
Хөрөнгө оруулалтын өгөөж		30.02%	31.85%

Нийт эздийн өмчийн өгөөж ROE (хувиар)



Нийт хөрөнгийн өгөөж ROA (хувиар)





Хөрөнгө оруулалтын өгөөж

Үнэт цаас гаргагчийн хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцохдоо хөрөнгө оруулалтын орлогыг нийт хөрөнгө оруулалтын дүнд харьцуулан тооцсон бөгөөд 2016 онд 30.02 хувь болон 2017 онд 31.85 хувьтай байгаа нь **сул хөрөнгөө ашигтай зарцуулж байгааг харуулж байна.**

Нийт хөрөнгийн өгөөж

2015 онд алдагдалтай ажилласны улмаас нийт хөрөнгийн өгөөж сөрөг утгатай гарсан байна. харин 2016 онд 4.71 хувь болон 2017 онд 10.6 хувьд хүрч үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагаа сайжирсан байна.

Дупонт шинжилгээ ROE

Эздийн өмчийн өгөөж буюу ROE харьцаа нь хувь нийлүүлсэн хөрөнгө бүрд компанийн ашигт ажиллагаа нь хувь нийлүүлэгчиддээ хэр их өгөөж өгч буйг харуулдаг үзүүлэлт юм.


Эздийн өмчийн өгөөж (ROE)-ийг тооцохдоо цэвэр ашгийн маржин, нийт хөрөнгийн эргэц, санхүүгийн хөшүүргийн үржвэрийг ашиглан дупонт шинжилгээ хийсэн. 2015 онд эздийн өмчийн өгөөж (ROE) -5.3 хувь байсан бол 2016 онд 10.7 хувь, 2017 онд 23.7 хувь болж өссөн байна. Уг өсөлтөд цэвэр ашгийн маржин 2017 онд 10.9 хувь болж өссөн нь голлон нөлөөлжээ.

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй салбар

2017 оны жилийн эцсийн байдлаар үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй даатгалын салбарт нийт ердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын 1, давхар даатгалын 1, даатгалын зуучлагч 42 компани тус тус үйл ажиллагаа явуулж байна.


Даатгалын зах зээлийн үзүүлэлт

Нийт хөрөнгө



Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

2017 оны жилийн эцсийн байдлаар даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 17.4 хувиар өсөж 244.7 тэрбум төгрөгт хүрсэн ба үүнээс ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 193.5 тэрбум төгрөг байна.


Хураамжийн орлого

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

Даатгалын компаниудын нийт хураамжийн орлого 2017 оны жилийн эцсийн байдлаар 144.3 тэрбум төгрөгт хүрсэн ба үүнээс ердийн

даатгалын компаниудын хураамжийн орлого 141.1 тэрбум төгрөгт хүрчээ.



Цэвэр ашиг

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

Даатгалын компаниудын цэвэр ашиг 2017 онд 13.2 тэрбум төгрөгт хүрсэн.

Үнэт цаас гаргагч нь нийт хураамжийн орлогын хэмжээгээр даатгалын салбарын 7.3 хувийг эзэлж байна.

Даатгалын салбарын хэмжээнд нийт хураамжийн орлогын 25 хувийг хөрөнгийн даатгал, 21 хувийг жолоочийн хариуцлагын даатгал, 13 хувийг авто тээврийн хэрэгслийн даатгал, үлдэх хувийг гэнэтийн осол

эмчилгээний, хариуцлагын, барилга угсралтын даатгал зэрэг даатгалууд эзэлж байна.

Нөхөн төлбөрийн хувьд даатгалын салбарын хэмжээнд жолоочийн хариуцлагын даатгал 34 хувийг, авто тээврийн хэрэгслийн даатгал 19 хувийг, хөрөнгийн даатгал 15 хувийг, үлдэх хувийг гэнэтийн осол, эмчилгээний даатгал, санхүүгийн даатгал зэрэг даатгалууд эзэлж байна.

Ногдол ашгийн бодлогын хураангуй

Өнгөрсөн хугацаанд

ногдол ашиг төлсөн байдал

2016 оны цэвэр ашгийн 30 хувьтай тэнцэх дүнгээр буюу нийт 129.34 сая төгрөгийн мөнгөөрх ногдол ашиг зарлаж, олгосон.

2017 оны 1.12 тэрбум төгрөгийн цэвэр ашгаас 50 хувийг нь буюу 562 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлэсэн.

Ард Даатгал ХХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 3 сарын 30-ны өдрийн 18/16 тоот тогтоолоор баталсан “Ногдол ашгийн бодлого”:

1. КТХ-ийн 47.1-д заасны дагуу ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх.

2. Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх.

3. Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүгдийг нь эргүүлэн авсан байх.

4. Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь 25-аас дээш хувиар багассан тохиолдолд ногдол ашгаас төлж дууссанаас хойш ажлын 10 хоногийн дотор эзэлдүүлэгчиддээ өөрийн хөрөнгийн үлдэгдлийг бичгээр мэдэгдэх үүргийг гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ.

5. Компанийн санхүүгийн байдлаас шалтгаалан жилийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас ногдол ашигт хуваарилна. Хуваарилах дүн нь компанийн тухайн жилийн **цэвэр ашгийн 30 хувиас 50 хувь** байна.

6. Бүртгэлийн өдрөөс ногдол ашиг төлөх хүртэлх хугацаанд өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад шилжүүлсэн тохиолдолд уг хувьцаанд ногдох ногдол ашгийг авах эрх нь хувьцаа эзэмшигчдэд үлдэнэ.

7. Хувьцаа эзэмшигчдэд төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг төлбөл зохих өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгаж, ногдол ашиг төлж эхэлсэн улирлын эцэст ногдол ашгаа аваагүй байгаа хувьцаа эзэмшигч бүрийн нэрээр өглөгийн бүртгэл тусгайлан бүртгэнэ.

Бизнес ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилт

Үнэт цаас гаргагч нь 5 жилийн хугацаанд топ 3 даатгалын компанийн нэг болох, ашигт ажиллагааг өсгөх юм.


Үнэт цаас гаргагч нь дараагийн 5 жилийн орлогын төлөвлөлтийг тооцоолохдоо Дэлхийн банкнаас гаргасан Монгол улсын

эдийн засгийн өсөлтийн таамаглалд үндэслэн даатгалын зах зээлийн өсөлтийг таамагласан ба 2018 онд зах зээлийн 9 орчим хувийг эзлэхээр, дараагийн жилүүдэд жил бүр зах зээлд эзлэх хувиа 1 хувиар нэмэгдүүлэхээр даатгалын хураамжийн орлогыг тооцоолжээ.


Орлогын таамаглал


сая төгрөгөөр	2018	2019	2020	2021	2022
Нийт хураамжийн орлого	13,000.00	15,921.84	20,106.72	24,793.74	31,245.23
Давхар даатгал	3,209.89	3,836.22	4,853.59	5,990.72	7,562.05
Буцаасан даатгал	120.2	144.24	173.09	207.71	249.26
Цэвэр хураамжийн даатгал	9,669.90	11,941.38	15,080.04	18,595.30	23,433.92
ОТХНС-ын өөрчлөлт	471.97	1,075.03	1,647.70	1,397.41	1,923.47
Орлогод тооцсон хураамж	9,197.93	10,866.35	13,432.34	17,197.90	21,510.45
Нөөц сангийн өөрчлөлт	702.55	979.32	442.06	512.53	671.38
Хөрөнгө оруулалтын орлого	1,400.00	1,900.00	2,500.00	3,000.00	4,000.00
Давхар даатгалын комисс	160.49	191.81	242.68	299.54	378.1
Нийт ашиг	6,554.27	7,774.17	10,423.14	13,393.75	16,947.56
Үйл ажиллагааны зардал	4,795.88	5,222.14	6,113.63	6,921.78	7,812.39
Үйл ажиллагааны ашиг/алдагдал	1,758.39	2,552.04	4,309.51	6,471.97	9,134.18
Үйл ажиллагааны бус ашиг/алдагдал	67.2	73.92	36.96	35.11	31.6
ТТӨА	1,825.59	2,625.96	4,346.47	6,507.08	9,165.78
Татвар	182.56	262.6	434.65	650.71	916.58
Цэвэр ашиг	1,643.03	2,363.36	3,911.83	5,856.37	8,249.20
Цэвэр ашгийн маржин	13%	15%	19%	24%	26%

Нийт хураамжийн орлого (сая төгрөг)



Цэвэр ашиг (сая төгрөг)



Нийт нөхөн төлбөр (сая төгрөг)

Хөрөнгө оруулалтын ТӨЛӨВЛӨЛТ

Татан төвлөрүүлсэн Хөрөнгө болон бусад эх үүсвэрээс суларсан мөнгөн хөрөнгийн хамт СЗХ-ны журамд нийцүүлэн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн байна. хөрөнгө


оруулалтын хэмжээ өссөнөөр хөрөнгө оруулалтын орлого нэмэгдэж, компанийн ашигт ажиллагаанд эерэгээр нөлөөлөх бололцоотой юм.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө (сая төгрөг)

Санхүүгийн байдлын таамаглал

сая төгрөгөөр	2018	2019	2020	2021	2022
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	384.76	178.74	1,013.43	2,199.21	2,364.27
Авлага	2,488.75	3,085.43	3,861.93	4,796.53	6,002.44
Хадгаламж	5,000.00	5,600.00	7,000.00	8,500.00	10,500.00
Богино хугацаат хөрөнгө оруулалт	6,550.00	7,850.00	10,700.00	14,600.00	18,000.00
Нийт эргэлтийн хөрөнгө	16,127.04	17,804.05	24,075.13	31,942.20	39,189.76
Үл хөдлөх хөрөнгө	1,800.00	1,800.00	800.00	-	3,000.00
Нийт эргэлтийн бус хөрөнгө	2,032.27	1,989.26	966.24	146.93	3,124.15
НИЙТ ХӨРӨНГӨ	18,159.31	19,793.31	25,041.37	32,089.13	42,313.91
Нийт богино хугацаат өр төлбөр	889.48	832.89	1,079.38	1,360.82	1,741.55
Нөөц сан	5,701.64	6,028.87	8,118.63	10,028.56	12,623.42
Нийт өр төлбөр	6,591.12	6,861.76	9,198.01	11,389.38	14,364.97
Эздийн өмч	8,750.00	8,750.00	8,750.00	8,750.00	8,750.00
Нийт хуримтлагдсан ашиг	2,818.18	4,181.54	7,093.37	11,949.74	19,198.94
Нийт эздийн өмч	11,568.18	12,931.54	15,843.37	20,699.74	27,948.94
НИЙТ ӨР ТӨЛБӨР БОЛОН ЭЗДИЙН ӨМЧ	18,159.30	19,793.30	25,041.38	32,089.12	42,313.91

Нийт хөрөнгө (сая төгрөг)





2. ҮНЭТ ЦААСНЫ **ТАНИЛЦУУЛГА**

Үнэт цаасны тухай

Үнэт цаас гаргагч

Үнэт цаасны төрөл

Арилжаалах хэлбэр

Санал болгож буй үнэ

Санал болгож буй хувьцааны тоо ширхэг

Татан төвлөрүүлэх үнийн дүн

Олон нийтэд санал болгох хувь

Зарцуулалт

Арилжаалах арга

Үнэт цаасны бүртгэл

Гаргасан хувьцааны тоо ширхэг

Шинээр хувьцаа гаргасны дараах тоо ширхэг

Ард Даатгал ХХК

Энгийн хувьцаа

Олон нийтэд нээлттэй хүрээнд

700 төгрөг

7,500,000 ширхэг (долоон сая таван зуун мянган ширхэг)

5,250,000,000 төгрөг (таван тэрбум хоёр зуун тавин сая төгрөг)

30%

Дүрмийн сан болон өөрийн хөрөнгө нэмэгдүүлэх

Тогтоосон үнийн арга

Монголын Хөрөнгийн Бирж

17,500,000 ширхэг (арван долоон сая таван зуун мянган ширхэг)

25,000,000 ширхэг (хорин таван сая ширхэг)

Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдээс гаргасан шийдвэр

Ард Даатгал ХХК-ийн 2018 оны 4 сарын 19-ны өдрийн ХЭХ-ын 07/18 тогтоолоор Ард Даатгал ХХК-ийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөх, нэмж 7,500,000 ширхэг хувьцааг нийтэд санал болгон гаргахыг зөвшөөрсөн байна.

Тус нэмж гаргаж буй хувьцааг МХБ-ийн 2018 оны 6 сарын 13-ны өдрийн А/74 тоот тушаалаар МХБ-ын I ангилалд бүртгэхийг зөвшөөрсөн бол СЗХ-оос 2018 оны 8 сарын 29-ний өдрийн 276 тоот тогтоолоор олон нийтэд санал болгохыг зөвшөөрсөн байна.

Үнэ тогтоосон үндэслэл

Үнэт цаас гаргагчийн ХЭХ-аар ТУЗ-д нэмж гаргаж буй хувьцааны үнийг тогтоох эрхийг олгосон ба ТУЗ-ийн 2018 оны 5 сарын 8-ны өдрийн 07/18 тогтоолоор нэмж гаргаж буй хувьцааны нэг бүрийн үнийг 700 төгрөгөөр нийтэд санал болгон худалдахыг зөвшөөрсөн.

Нийтэд санал болгох үнэт цаасны төрөл, тоо, хэлбэр, нэрлэсэн үнэ

Үнэт цаас гаргагч нь компанийн 30 хувьтай тэнцэх энгийн хувьцаа буюу нэг бүр нь 700 төгрөгийн үнэтэй 7,500,000 ширхэг хувьцааг нэмж гарган МХБ-д бүртгүүлж олон нийтэд санал болгож байна.

Хувьцаа гаргасны дараах хувьцаа эзэмшигчдийн бүтэц:



Нэмж хувьцаа гаргасны дараагаар Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь 16,679,250 ширхэг хувьцаа буюу компанийн 66.72 хувийг,

Энержи Интернэйшнл Капитал ХХК нь 820,750 ширхэг хувьцаа буюу 3.28 хувийг, олон нийт 30 хувийг тус тус эзэмшинэ.

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц	Хувьцаа гаргахаас өмнө		Хувьцаа гаргасны дараа	
	Хувьцааны тоо	Эзэмшлийн хувь	Хувьцааны тоо	Эзэмшлийн хувь
Ард Санхүүгийн Нэгдэл ХК	16,679,250	95.31%	16,679,250	66.72%
Энержи Интернэйшнл Капитал ХХК	820,750	4.69%	820,750	3.28%
Олон нийт	-	-	7,500,000	30%
Нийт	17,500,000	100%	25,000,000	100%



Бизнесийн үнэлгээ

БДО Аудит ХХК нь мэргэжлийн багийн түвшинд шүүн тунгааж хорогдуулсан мөнгөн урсгалын аргын үр дүн нь үнэлгээний өдрийн байдлаар бизнесийн зах зээлийн үнэ цэнийг илүү сайн төлөөлж чадна. Бизнесийн 100 хувийн өмчийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэнэ 18,910,026 - 20,371,190 мянган төгрөг байх үндэслэлтэй байна гэж дүгнэжээ. Хорогдуулсан мөнгөн урсгалын загварын үед мөнгөн урсгалын тооцооллыг хийхдээ үнэлгээчид нь удирдлагаас ирүүлсэн дунд хугацааны бизнесийн төлөвлөгөөнд үндэслэсэн ба хорогдуулах хүүний тооцооллыг өөрсдийн шинжилгээгээр 23.0 хувиас 24.0 хувь байхаар тооцсон. Үүн дээр нэмээд дараах арга зүй, параметруудийг мөнгөн урсгалын төсөөлөлд ашигласан:

- Бизнесийн үлдэх үнэ цэнэ буюу эцсийн

мөнгөн урсгалыг Гордоны тогтмол өсөлтийн загвар ашиглан тодорхойлсон.

- Урт хугацааны өсөлтийн параметрийг сонгохдоо Сангийн яам-ны урт хугацааны эдийн засгийн өсөлтийн судалгаанд тодорхойлсон 3.6 хувиас 5.6 хувь байхаар сонгон авсан.

- Урт хугацааны хүлээгдэж буй инфляци 6.5 хувь байна.

- Хувьцаат капиталын цэвэр дансны үнэ таамагласан хугацааны туршид өөрчлөгдөхгүй гэж таамагласан.

- Хорогдуулах хүүний үеийг дундаж үеийн аргаар тооцсон.

Хорогдуулсан мөнгөн урсгалын загварын үр дүнгээс үзэхэд үнэлгээний өдрийн бизнесийн үнэ цэнэ дараах байдалтайгаар гарсан байна.

Үнэлгээний байгууллага:

БДО Аудит ХХК

Үнэлгээ төрөл:

Бизнес болон хөрөнгийн үнэлгээ

Бизнесийн үнэлгээ

Жишиг арилжааны аргаар – 23,660,980,000 төгрөг

Жишиг компанийн аргаар – 23,078,912,000 төгрөг

Хорогдуулсан мөнгөн урсгалын аргаар – 20,371,190,000 төгрөг

Нэгж хувьцааны үнэ 1,164 төгрөг

Олон нийтэд санал болгож буй үнэлгээ

12,250,000,000 төгрөг (39.9 хувиар бага)

Нэгж хувьцааны үнэ 700 төгрөг

Сонгосон хорогдуулах хүү болох 23%-иар тооцох үед:

Үнэ цэнийн тооцоолол	ТЖ18Т	ТЖ19Т	ТЖ20Т	ТЖ21Т	ТЖ22Т
Тасралттай мөнгөн урсгал	837,404	349,179	1,695,695	3,316,137	5,310,117
Тасралтгүй мөнгөн урсгал	-	-	-	-	28,348,291
Хорогдуулах үе	0.50	1.50	2.50	3.50	4.50
Хорогдуулах хүчин зүйл	0.90	0.73	0.60	0.48	0.39
Хорогдуулсан дискрет мөнгөн урсгал	754,792	255,843	1,010,317	1,605,263	2,089,593
Хорогдуулсан эцсийн мөнгөн урсгал					11,155,382
100%-ийн оролцооны үнэ цэнэ (мянган төгрөг)					20,371,190
100%-ийн хувь оролцооны үнэ цэнэ (мянган					8,393

ам. доллар)

Хорогдуулах хувийн дээд хязгаар болох 24%-иар тооцох үед:

Үнэ цэнийн тооцоолол	ТЖ18Т	ТЖ19Т	ТЖ20Т	ТЖ21Т	ТЖ22Т
Тасралттай мөнгөн урсгал	802,404	261,679	1,608,195	3,228,637	5,222,617
Тасралтгүй мөнгөн урсгал	-	-	-	-	26,514,975
Хорогдуулах үе	0.50	1.50	2.50	3.50	4.50
Хорогдуулах хүчин зүйл	0.90	0.72	0.58	0.47	0.38
Хорогдуулсан дискрет мөнгөн урсгал	720,316	189,415	938,987	1,519,214	1,981,601
Хорогдуулсан эцсийн мөнгөн урсгал					10,060,493
100%-ийн оролцооны үнэ цэнэ (мянган төгрөг)					18,910,026
100%-ийн хувь оролцооны үнэ цэнэ (мянган					7,791

ам. доллар)

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт

Үнэт цаас гаргагч нь МХБ-д бүртгүүлж олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөр компанийн дүрмийн сан болон өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх бөгөөд СЗХ-оос баталсан журмын хүрээнд хөрөнгө оруулалт хийж ажиллахаар төлөвлөөд байна.

Үнэт цаас гаргагч нь нөөц сан болон дүрмийн сангийн хөрөнгөөр МХБ-ийн 1, 2-р ангиллын хувьцаа, компанийн бонд, ЗГҮЦ, үл хөдлөх хөрөнгө, хугацаатай хадгаламж, итгэлцлийн үйлчилгээ болон бусад санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулж өндөр өгөөж хүртсэн туршлагатай компани юм. Иймээс үнэт цаас гаргагч нь эргэлтийн хөрөнгийн чөлөөт эх үүсвэрээ ашиглан үр ашигтай хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийснээр өндөр өгөөж хүртэх, компанийн ашигт байдал нэмэгдэх, үнэ

цэнийг нэмэгдүүлэх бололцоотой бөгөөд өнгөрсөн жилүүдэд үнэт цаас гаргагчийн хөрөнгө оруулалт, түүнээс олох орлого тогтвортой өссөөр 2017 оны байдлаар хөрөнгө оруулалт 5.78 тэрбум төгрөгт, хөрөнгө оруулалтын орлого 1.4 тэрбум төгрөгт тус тус хүрчээ. Мөн 2015 онд хөрөнгө оруулалтын олз нийт хөрөнгө оруулалтын 18.23 хувийг эзэлж байсан бол 2017 онд 24.2 хувийг эзэлсэн байна.

Үнэт цаас гаргагч нь олон нийтээс татан төвлөрүүлэхээр тооцоолсон 5.25 тэрбум төгрөгийг СЗХ-ны холбогдох журмын дагуу хадгаламж, ББСБ-ын итгэлцэл, ЗГҮЦ, МХБ дээрх үнэт цаас, компанийн бонд, үл хөдлөх хөрөнгө, хөрөнгө оруулалтын сан зэрэг хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн.

Үнэт цаас гаргагч нь дараагийн 5 жилийн хугацаанд хийх хөрөнгө оруулалт:

№	Хөрөнгө оруулалтууд	2017	БТ2018	БТ2019	БТ2020	БТ2021	БТ2022
1	Хадгаламж	2,600.00	5,000.00	5,500.00	7,000.00	8,500.00	10,500.00
2	ББСБ итгэлцэл	60.00	550.00	750.00	1,300.00	2,300.00	3,500.00
3	ЗГҮЦ	1,386.40	-	300.00	1,000.00	1,200.00	1,000.00
4	МХБ дээрх үнэт цаас	639.40	2,700.00	3,000.00	3,400.00	4,400.00	5,000.00
5	Компанийн бонд	1,097.70	1,500.00	1,800.00	2,400.00	3,500.00	4,500.00
6	Үл хөдлөх хөрөнгө	1,800.00	1,800.00	1,800.00	800.00	-	3,000.00
7	Хөрөнгө оруулалтын сан	-	1,800.00	2,000.00	2,600.00	3,200.00	4,000.00
	Нийт хөрөнгө оруулалт	7,583.70	13,350.00	15,250.00	18,500.00	23,100.00	31,500.00

Үнэт цаасны арилжаанд хэрхэн оролцох вэ?

Хувьцаа худалдан авах хөрөнгө оруулагчид дараах зааврын дагуу анхдагч зах зээлийн арилжаанд оролцоно.

Данс нээлгэх



МХБ-д бүртгэлтэй ҮЦК-иудаас сонгож, үнэт цаасны данс нээлгэнэ.

Мөнгөө байршуулах



Үнэт цаасны дансанд дараах зааврын дагуу хувьцаа худалдан авахад шаардагдах мөнгө байршуулна.

Захиалга өгөх



Сонгон үйлчлүүлж буй ҮЦК-даа хувьцаа худалдан авах захиалга өгөх, гэрээ байгуулах.

Нэр дээр шилжих



Анхдагч зах зээлийн арилжаа хаагдсан өдөр үнэт цаас харилцагчийн нэр дээр шилжинэ.

Хүлээн авагч банк: Арилжаа төлбөр тооцоо банк

Хүлээн авах данс: XXXX (ҮЦК-ийн код) XXXXXXXX

(Харилцагчийн үнэт цаасны дансны дугаар)

Хүлээн авагч: (данс эзэмшигчийн нэр)

Утга: Ард Даатгал хувьцаа худалдан авах мөнгө

Үнэт цаас гаргагч компани: **Ард Даатгал ХХК**

Төв оффис

📍 Ард Санхүүгийн Нэгдлийн байр, II давхар,
Ерөнхий Сайд Амарын гудамж, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот 14200, Монгол улс

/// цэнэг.эрдэмтэй.өнгөлөх

☎ 7720 0089

Ард Шангри-Ла салбар

📍 Шангри-Ла худалдаа, үйлчилгээний
төвийн I давхар

/// хөтөч.лугших.бүтээлчид

☎ 7707 8181

Ард Сэнтрал Тауэр салбар

📍 Сэнтрал Тауэр, I давхар

/// оюунлаг.азтанд.өтгөрөх

☎ 7707 8282

#2

2015 онд
Тээврийн
хэрэгслийн
даатгалын
хохирол
төлөлтийн
харьцаа
үзүүлэлт

#3

2016 онд
Жолоочийн
хариуцлагын
даатгалын
хохирол
төлөлтийн
харьцаа
үзүүлэлт

100

Гаруй
ажилчидтай

24

Салбар

10%

Зах зээлд
эзлэх хувь

24

Үйл
ажиллагаа
явуулсан жил

238

Төлөөлөгчдийн
тоо

64K

Даатгуулагчийн
тоо

6

Хамтран
ажилладаг
банкууд

20

Хамтран
ажилладаг
брокерууд

Хувьцааны захиалгаа доорх
хаягаар ирүүлнэ үү. Бид тантай
эргэн холбогдох болно.

bolomj.ard.mn



IPO

**БОЛОМЖООС
БИТГИЙ
ХОЦОР**